

Үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилт

СУУРЬ СУДАЛГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Б.Хишигсайхан
Судлаач, Хүний эрхийн магистр



ТАНИЛЦУУЛГЫН БҮТЭЦ

- Үндэстний цөөнх, олон улсын эрх зүй дэх цөөнхийн хамгаалалт, үндэстний цөөнхийн эрх
- Судалгааны зорилго, зорилт, аргачлал, зорилтот бүлэг, объект
- Судалгааны шинэлэг тал, ач холбогдол
- Судалгааны дүгнэлт



Үндэстний цөөнх гэж хэн бэ?

- “...тухайн улсад зонхилох байр суурь эзэлдэггүй бөгөөд тодорхой үндэстэн, угсаатан, шашин шүтлэг эсвэл хэлний хувьд олонх хүн амаас ялгардаг хувь хүмүүсийг ...”

UNHCHR, Fact Sheet No18, Minority Rights



Цөөнхийн эрхийн хамгаалалт олон улсын баримт бичигт

- Оршин байх
- Тусгаарлагдахгүй байх
- Үл ялгаварлан гадуурхагдах
- Уусгахгүй байх



Үндэстний цөөнхийн эрх

- соёлоо баримтлах, хадгалан үлдэх
- шашнаа шүтэх, шашныхаа зан үйлийг үйлдэх
- эх хэлээрээ сурах, харилцах



Судалгааны зорилго

- Монгол Улс дахь үндэстний цөөнхийн эрх, эрх чөлөөний төлөв байдлыг тодорхойлох



Зорилтууд

- Үндэстний цөөнхийн эрхийн асуудлаар гарсан олон улсын баримт бичиг, стандартыг судлах
- Үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулах сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээний хэрэгцээ, агуулгыг тодорхойлох
- Казах хэлнээ хөрвүүлэгдсэн хүний эрхийн баримт бичгүүд, холбогдох хууль тогтоомжийн талаар судалж, энэ чиглэлээрх хэрэгцээг тодорхойлох
- Үндэстний цөөнхийн дунд амьдарч байгаа цөөнх иргэдийн эрхийн хэрэгжилтэд дүгнэлт хийх



Судалгааны аргачлал

- Анкет
- Сурвалжлага
- Фокус бүлэг
- Ажиглалт
- Баримт бичиг судлах



Судалгааны зорилтот бүлэг

- 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогоор 102,983 буюу нийт хүн амын 4,3 хувь нь казах үндэстэн.
 - Исламын шашин шүтдэг.
 - Казах хэлтэй.
 - Наурыз, бүргэдийн ан г.м өвөрмөц соёлтой.
- БӨ аймгийн хүн амын 11,3 хувийг эзэлдэг урианхай, тува, халх, дөрвөд, баядууд



Судалгааны объект

<i>Аймаг, хот, дүүрэг</i>	<i>Анкет</i>	<i>Фокус групп</i>	<i>Ажиглалт</i>	<i>Кейс судалгаа</i>
Баян- ^а лгий, ^а лгий хот	350	3	4	3
Буянт сум	74	3	-	-
Цэнгэл сум	94	3	-	1
Толбо сум	80	2	-	-
Ховд, Ховд хот	225	-	-	-
Ховд сум	62	-	-	-
Буянт сум	56	-	-	-
УБ, Налайх дүүрэг	113	-	-	-
НИЙТ	1054	11	4	4

Судалгааны шинэлэг тал, ач холбогдол

- МУ дахь үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилтэд олон улсын хүний эрхийн эрх зүйн үүднээс цогц хандсан.
- Үндэстний цөөнхийн эрхийн талаарх олон улсын баримт бичиг, НҮБ-ын Хороодын гомдол шийдвэрлэх ажиллагаа, МУ-ын ЗГ-ын илтгэлүүд, түүнд НҮБ-ын Хороодоос ирүүлсэн дүгнэлт, зөвлөмж, судалгаа, шинжилгээний ажил зэрэг мэдээллийн баазыг бий болгосон.
- Үндэстний цөөнхийн асуудлаар бодлого, шийдвэр боловсруулахад судалгааны тоо баримт, дүн шинжилгээ, зөвлөмж нь чухал эх сурвалж болох боломжтой.



СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Ерөнхий асуудлаар:

- МУ-ын ЗГ-аас НҮБ-ын Хороодод явуулж буй илтгэлд үндэстний цөөнхийн эрхийн асуудал тодорхой тусахгүй байна.
- Статистик мэдээлэл үндэстэн, ястнаар гардаггүй тул энэ чиглэлээр тодорхой асуудлуудад дүн шинжилгээ хийх боломжийг хязгаарлаж байна.
- Үндэстний цөөнхийн эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого, баримт бичиг байхгүй байна.
- Үндэстний цөөнх болон бусад үндэстэн ястны эвсэн найрамдах, бие биенийхээ хэл, соёл, шашинд хүндэтгэлтэй хандахад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн арга хэмжээ үгүйлэгдэж байна.
- БӨ аймаг нь төвөөс алслагдсан, дэд бүтэц хөгжөөгүй, томоохон үйлдвэр, ААН байхгүй зэрэг байдал нь казах иргэд болон тэдний дунд амьдарч буй цөөнхөд ажилгүйдэл, ядууралд нэрвэгдэх, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох эрхээ эдлэхэд нь ихээхэн таагүй нөлөө үзүүлж байна.



СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Казах иргэдийн үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилт:

- 1990 оны эхээр казах иргэд олноор БНКУ-д шилжин суурьших болсонтой холбогдон иргэний харъяалалгүй болох, давхар харъяалалтай болох зэрэг зөрчил ихээр гарсан.
- Иргэний харъяалалаа сэргээх үйл явц хэт удаан байгаагаас казах иргэд зарим үндсэн эрхээ эдлэхэд хүндрэл гарч байна.
- Бусад орон нутагт амьдарч буй казах иргэд үндэстний цөөнхийн эрхээ эдлэх асуудал ихээхэн хязгаарлагдмал байна.
- Үндэстний цөөнхийн эх хэлээрээ сурах боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой алхмууд хийгдэж байгаа ч энэ нь казах хүүхдүүдийн эрэлт хэрэгцээнд тэр бүр нийцэхгүй байна.
- Эх хэл дээрээ мэдээлэл авах эрх үндсэндээ хэрэгжихгүй байна.
- Казах иргэд төрийн албан ёсны хэл сурахад төрөөс дорвитой дэмжлэг үзүүлэхгүй, казахууд ч төдийлөн хичээл зүтгэл гаргахгүй байна.



СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

БӨ аймагт амьдарч буй цөөнх иргэдийн асуудал:

- Үндэстний цөөнхийн дунд амьдарч буй цөөнхийн асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна.
- БӨ аймагт амьдарч буй буддын шашинтай иргэдийн хувьд шашнаа шүтэх, шашны зан үйлээ үйлдэхэд тодорхой хүндрэл учирдаг байна.
- Үндэстний цөөнх болон бусад үндэстэн ястны эвсэн найрамдах, бие биенийхээ хэл, соёл, шашинд хүндэтгэлтэй хандахад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн арга хэмжээ үгүйлэгдэж байна.



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА!

